



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 03 сарын 12 өдөр

Дугаар A/138

Арвайхээр

**Бүрд сумын Засаг даргын Тамгын газрын
бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 33.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүрд сумын Засаг даргын Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг тогтоож, бүтэц, орон тоог хавсралтаар баталсугай.

2. Хуульд заасан эрх хэмжээний дагуу сумын Засаг даргын Тамгын газрын мэргэжилтнүүдийн албан тушаалын чиг үүргийг тодорхойлон, хэрэгжүүлж ажиллахыг сумын Засаг дарга (Г.Баярмөнх), Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Гачмаа) нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т үүрэг болгосугай.

3. Шинээр батлагдсан бүтэц, орон тоог 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг сумын Засаг дарга (Г.Баярмөнх)-д даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан “Бүрд сумдын Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” 2018 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн а/489 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100312

Аймгийн Засаг даргын 2019 оны 03
дугаар сарын 12-ны өдрийн 1138 дугаар
захирамжийн хавсралт

БҮРД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
БҮТЭЦ, ОРОН ТОО

№	Албан тушаалын нэр	Орон тоо
1.	Засаг дарга	1
2.	Засаг даргын орлогч	1
3.	Тамгын газрын дарга	1
4.	Санхүүгийн албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч	1
5.	Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн	1
6.	Төрийн захиргааны асуудал хариуцсан мэргэжилтэн	1
7.	Байгаль орчны хяналтын улсын байцаагч	1
8.	Гэр бүл, хүүхэд, залуучууд, нийтийн биеийн тамир хариуцсан мэргэжилтэн	1
9.	Хүнс, газар тариалан, хоршоо, экстэйншн, үйлчилгээний салбарын асуудал хариуцсан мэргэжилтэн	1
10.	Мал аж ахуйн үйлдвэрлэлийн технологи, малын үржил бүртгэл, бэлчээр, тэжээлийн асуудал хариуцсан мэргэжилтэн	1
11.	Жижиг, дунд үйлдвэрлэл, сум хөгжүүлэх сан, үндсэн чиглэл, төсөл, хөтөлбөр, олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн	1
12.	Нягтлан бодогч	1
13.	Багийн Засаг дарга	5
14.	Архив, бичиг хэргийн эрхлэгч	1
15.	Нярав-үйлчлэгч	1
16.	Жолооч	1
	Бүгд	20